



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2012 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 8-99

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төвбанк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь заалт, 22 дугаар зүйл, Монголбанкны Захирлуудын зөвлөлийн 2012 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.“Банкны нэгжийн журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
- 2.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Б.Лхагвасүрэн)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Л.ПҮРЭВДОРЖ



14 0838

Tushaal2012.doc

БАНКНЫ НЭГЖИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

УХИ0014

1.1. Энэ журмын зорилго нь Банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийт үндэслэн банкны нэгж байгуулахад зөвшөөрөл олгох, баримт бичгийг хянах, олгосон зөвшөөрлийг хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ журамд хэрэглэсэн нэр томьёог дор дурьдсан утгаар ойлгоно:

1.2.1."Банкны нэгж" гэж Банкны тухай хуулийн 3.1.13-т заасныг хэлнэ.

1.2.2."Банкны төв" гэж Улаанбаатар хотноо байрлах банкны төв байгууллагыг хэлнэ.

1.2.3."Банкны салбар" гэж Монголбанкны тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагааг бүхэлд нь буюу зарим хэсгийг эсхүл хэсэгчлэн эрхэлдэг хуулийн этгээдийн эрхгүй нэгжийг хэлнэ. Банкны төвөөс салбарын үйл ажиллагааг удирдах, хянах, зохион байгуулах ажлыг гүйцэтгэж, салбарын хэмжээнд мөрдөгдөх зээлийн эрх хэмжээний хязгаарлалтыг тогтооно. Салбар нь өөрийн харьяалалд тооцооны төв, тооцооны касстай байж болно.

1.2.4."Банкны тооцооны төв" гэж хуулийн этгээд, иргэдийн харилцах, хадгаламж байршуулах, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх, харьяалах салбар болон банкны төвөөс тогтоосон зээлийн эрх хэмжээний хязгаарлалтын хүрээнд зээлийн үйл ажиллагаа эрхлэх банкны төв, салбарын харьяалалд байх нэгжийг хэлнэ.

1.2.5."Банкны тооцооны касс" гэж хуулийн этгээд болон иргэдийн харилцах, хадгаламж байршуулах, гадаад төлбөр тооцооны энгийн зөвшөөрлийн хүрээнд гадаад валиут худалдах, худалдан авах болон төлбөр тооцооны үйлчилгээ эрхлэх салбарын харьяалалд байх нэгжийг хэлнэ.

1.2.6."Банкны төлөөлөгчийн газар" гэж банкны аливаа үйл ажиллагаа эрхэлдэггүй, банкны оршин байгаа газраас өөр газар байрладаг бөгөөд банкны хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулах нэгжийг хэлнэ.

1.3. Монголбанкаас банкны төлөөлөгчийн газар, салбар, тооцооны төв байгуулахад ерөнхий зөвшөөрөл олгоно.

1.4. Банк нь тооцооны касс байгуулах, татан буулгах асуудлыг өөрөө шийдвэрлэнэ.

1.5. Банкны нэгжийг байгуулахтай холбогдуулан үүсэх улсын тэмдэгтийн хураамж болон ажил үйлчилгээний шимтгэлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрээр тогтооно.

**Хоёр. Банкны салбар, тооцооны төв байгуулах зөвшөөрөл олгох,
түдгэлзүүлэх, матгалзах, хүчингүй болгох**

2.1. Монголбанк нь дараахь шаардлагыг хангасан банкинд салбар, тооцооны төв байгуулах ерөнхий зөвшөөрөл олгоно.

2.1.1. Банкны тухай хуулийн 16 болон 17 дугаар зүйл, Монголбанкаас тогтоосон

банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 6 сарын хугацаанд тогтмол хангаж ажилласан,

2.1.2. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2001 оны 444 дүгээр тушаалаар баталсан “Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь иж бүрэн шалгалт хийж үнэлгээ, дүгнэлт өгөх журам”-ын дагуу хийгдсэн үнэлгээгээр “Дунд” ба түүнээс дээш үнэлгээ авсан,

2.1.3. Зөвшөөрөл хүсэх үед албадлагын арга хэмжээний хүрээнд банкны зарим үйл ажиллагааг түдгэлзүүлэх, хязгаарлах, хянач томилох арга хэмжээ авагдаагүй, хэвийн үйл ажиллагаа явуулж байх.

2.2. Хяналт шалгалтын газар нь энэхүү журмын 2.1-т заасан шаардлагыг хянасны үндсэн дээр тухайн хугацаанд салбар, тооцооны төв байгуулах ерөнхий зөвшөөрөл олгох эсэх талаар санал боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулна.

2.3. Монголбанкны Ерөнхийлөгч Хяналт шалгалтын газрын саналыг үндэслэн банк бүрээр салбар, тооцооны төв байгуулах ерөнхий зөвшөөрлийг олгоно.

2.4. Ерөнхий зөвшөөрлийг нэг жилд 2 удаа тус бүр 6 сар хүртэлх хугацаатай олгоно.

2.5. Банк нь Монголбанкны Ерөнхийлөгчийн олгосон ерөнхий зөвшөөрлийг үндэслэн салбар, тооцооны төв байгуулсан талаар Монголбанкинд тухай бүр мэдэгдэж, шинээр байгуулсан болон байршилыг өөрчилсөн салбар, тооцооны төвийн мэдээллийг банкны гэрчилгээний хавсралтад тэмдэглүүлэн баталгаажуулна.

2.6. Салбар, тооцооны төв байгуулах ерөнхий зөвшөөрлийн хураамж төлсөн баримтыг үндэслэн Төлбөр тооцоо, бүртгэлийн газар нь ажлын 3 хоногт багтаан тухайн салбар, тооцооны төвд төлбөр тооцоо гүйцэтгэх код олгоно.

2.7. Банк банкны нэгж байгуулах, татан буулгах, үйл ажиллагааг хязгаарлах, өөрчлөн байгуулах (нэгтгэх, нийлүүлэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх), байршилыг нь өөрчлөх (байршилыг өөр хооронд нь солих, шилжүүлэх) тухай бүрт шийдвэр гаргана. Шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор харилцагчдад мэдээлэх ба Монголбанкинд шийдвэрийг албан бичгээр ирүүлж бүртгүүлнэ.

2.8. Төлбөр тооцоо, бүртгэлийн газар энэ журмын 2.7-д заасан шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан банк хоорондын төлбөр тооцоо гүйцэтгэх банкны кодчиллын системд өөрчлөлт оруулна.

2.9. Монголбанкны хяналт шалгалтаар банк нь банкны тухай хууль тогтоомж зөрчсөн болон энэ журамд заасан шаардлагыг хангахгүй болсон нь тогтоогдвол ерөнхий зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацааар түдгэлзүүлж болно.

2.10. Монголбанк нь харилцагчдын эрх ашигт харшилсан, тухайн банкны хэвийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварт хүндэрл учруулж болзошгүй нөхцөл үүссэн буюу банкны тухай хууль тогтоомж болон энэ журамд заасан шаардлагыг хангахгүй болсон нь Монголбанкны хяналт шалгалтаар тогтоогдвол банкны нэгж байгуулсан шийдвэрийг хүчингүй болгож болно.

2.11. Банкинд хүлээлгэх албадлагын арга хэмжээний хүрээнд банкны нэгж байгуулах зөвшөөрлийг Монголбанкаас хүчингүй болгосон тохиолдолд ерөнхий зөвшөөрөл хүчингүй болсонд тооцно.

**Гурав. Гадаадын банкны төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрөл олгох,
түдгэлзүүлэх, татгалзах, хүчингүй болгох**

3.1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны А-80 дугаар тушаалаар батлагдсан “Банкны зөвшөөрлийн журам”-ын 2.3-т тавигдсан шаардлагыг хангаж байгаа гадаадын банк нь Монгол Улсад төлөөлөгчийн газар нээх тухай хүсэлтээ Монголбанкинд ирүүлнэ.

3.2. Гадаадын банк нь Монгол Улсад төлөөлөгчийн газар байгуулахдаа Банкны тухай хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан болон дор дурьдсан баримт бичгийг англи, монгол хэлээр нотариатаар гэрчлүүлэн Монголбанкинд ирүүлнэ:

3.2.1. Төлөөлөгчийн газар үүсгэн байгуулах зөвшөөрөл олгохыг хүссэн гадаадын банк, санхүүгийн байгууллагын хүсэлт,

3.2.2. Гадаадын банк, санхүүгийн байгууллагын захирлуудын зөвлөл, эсхүл түүнтэй адилтгах эрх бүхий удирдлагаас Монгол Улсад төлөөлөгчийн газар байгуулахаар гаргасан шийдвэр,

3.2.3. Гадаадын банкны тухайн улсын банк байгуулах зөвшөөрөл олгох болон хяналт шалгалтын эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн болохыг нотлох баримт, Монгол Улсын нутаг дэвсгэрт банкны төлөөлөгчийн газар байгуулахыг зөвшөөрсөн тухай албан ёсны шийдвэр,

3.2.4. Төлөөлөгчийн газрын удирдлагаыг томилсон тухай шийдвэр,

3.2.5. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар баталгаажуулсан гадаадын банк, санхүүгийн байгууллагын сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан,

3.2.6. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэглэл тогтоодог байгууллагын тогтоосон зэрэглэл,

3.2.7. Дараах асуудлыг тусгасан төлөөлөгчийн газрын дүрэм:

3.2.7.1. Оршин байх газрын албан ёсны хаяг,

3.2.7.2. Бүтэц, зохион байгуулалт, эрхлэх үйл ажиллагаа,

3.2.7.3. Гадаадын банк, санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах зарчим, эрх үүрэг, хүлээх хариуцлага,

3.2.7.4. Үйл ажиллагааны зарчим, татан буулгах, өөрчлөн байгуулах үндэслэл, гүйцэтгэх удирдлагын эрх үүргийн хэмжээ, хүлээх хариуцлага,

3.2.7.5. Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд тавих хяналт,

3.2.7.6. Бусад шаардлагатай асуудал.

3.2.8. Энэхүү журмын 2 дугаар хавсралтын дагуу Төлөөлөгчийн газрын гүйцэтгэх удирдлагын анкет,

3.2.9. Төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд мөрдөх эрх зүйн акт /журям, заавар гэх мэт/. Энэхүү эрх зүйн акт нь Монгол Улсын хууль тогтоомж, Монголбанкаас баталсан эрх зүйн акттай нийцсэн байх,

3.2.10. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт,

3.2.11.Гадаадын банк, санхүүгийн байгууллага нь Монгол Улсад төлөөлөгчийн газар байгуулахад дээрх шаардлагыг хангасан гэж үзвэл тухайн харьяалах улсын төв банк буюу банкны хяналт шалгалтын эрх бүхий байгууллагаас гадаадын банк, санхүүгийн байгууллагад авсан албадлагын арга хэмжээний талаархи мэдээлэл,

3.2.12. Бусад шаардлагатай материал.

3.3.Монголбанкнаас холбогдох баримт бичгийг судлан нэмэлт баримт бичиг бурдүүлэх шаардлагатай гэж үзвэл төлөөлөгчийн газрын үүсгэн байгуулагчдад энэ тухай албан бичгээр мэдэгдэнэ.

3.4.Гадаадын банк, санхүүгийн байгууллагын төлөөлөгчийн газар нь гадаадын банк, санхүүгийн байгууллагынхаа оноосон нэрийн дараа "..... банкны төлөөлөгчийн газар" гэсэн нэртэйгээр үйл ажиллагаа явуулна.

3.5.Хяналт шалгалтын газар нь энэ журмын 3.2-т заасан баримт бичгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны А-80 дугаар тушаалаар баталсан "Банкны зөвшөөрлийн журам"-ын 3.1-т заасан зарчмыг баримтлан энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу хянаж, зөвшөөрөл олгох эсэх саналаа Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулна.

3.6.Төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрээр олгоно.

3.7.Монголбанк нь гадаадын банкны төлөөлөгчийн газар банкны тухай хууль тогтоомж зөрчсөн болон энэ журамд заасан шаардлагыг хангахгүй болсон нь Монголбанкны хяналт шалгалтаар тогтоогдвол зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.

3.8.Монголбанк нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны А-80 дугаар тушаалаар баталсан "Банкны зөвшөөрлийн журам"-ын 3.6-д заасан үндэслэлээр Төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрөл олгохоос татгалзаж болно.

3.9.Монгол Улсын хуулиар буюу Засгийн газрын шийдвэрээр гишүүнээр элссэн олон улсын санхүүгийн хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөгчийн газарт энэхүү журам хамаарахгүй.

Дөрөв. Гадаад улсад банкны нэгж байгуулах зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, татгалзах, хүчингүй болгох

4.1.Монгол Улсад бүртгэлтэй банк гадаад улсад банкны нэгж байгуулахдаа Монголбанкнаас зөвшөөрөл авна.

4.2.Гадаад улсад банкны нэгж байгуулах зөвшөөрөл хүссэн банк дараахь шаардлагыг хангасан байна:

4.2.1.Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаас хойш 2-оос дээш жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан,

4.2.2.Банкны тухай хуулийн 16 болон 17 дугаар зүйл, Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 1 жилийн турш тогтмол хангаж ажилласан,

4.2.3.Монголбанкнаас тухайн банкны санхүүгийн үйл ажиллагаа, төлбөрийн чадварт хийсэн газар дээрх иж бүрэн шалгалтаар "Сайн" ба түүнээс дээш үнэлгээ авсан.

4.3. Энэ журмын 4.2-т заасан шаардлагыг хангасан банк гадаад улсад банкны нэгж байгуулах хүсэлтийг дараахь баримт бичгийн хамт Хяналт шалгалтын газарт ирүүлнэ:

4.3.1. Гадаад улсад банкны нэгж байгуулах тухай банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр,

4.3.2. Эрхлэх үйл ажиллагааны чиглэл,

4.3.3. Тухайн улсад банкны нэгж байгуулах зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын урьдчилсан зөвшөөрөл, эсхүл энэ талаар харилцан тохиролцсон тухай албан бичиг,

4.3.4. Тухайн улсад банкны нэгж ажиллуулах эдийн засгийн үндэслэл, нэгжийн дүрэм, стратеги төлөвлөгөө.

4.4. Хяналт шалгалтын газар нь гадаад улсад банкны нэгж байгуулах хүсэлтийг хүлээн авч энэ журмын 4.2-т заасан шаардлагыг хангасан эсэх, 4.3-т заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн ирүүлсэн эсэхийг ажлын 30 хоногийн дотор хянаж дүгнэлт гаргана.

4.5. Хяналт шалгалтын газрын дүгнэлтийг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч гадаад улсад банкны нэгж байгуулах зөвшөөрөл олгоно. Зөвшөөрөлд эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхой заана.

4.6. Монголбанкны хяналт шалгалтаар банк нь банкны тухай хууль тогтоомж зөрчсөн болон энэ журамд заасан шаардлагыг хангахгүй болсон нь тогтоогдвол нэгжийн зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.

4.7. Банк нь энэ журмын 4.2-т заасан шаардлагыг хангаагүй, 4.3-т заасан баримт бичиг нь хуурамч, худал ташаа мэдээлэл агуулсан бол гадаад улсад банкны нэгж байгуулах зөвшөөрөл олгохоос татгалзана.

4.8. Хяналт шалгалтын газар нь гадаад улсад банкны нэгж байгуулах зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэрийг банкинд хүргүүлж холбогдох баримт бичгийг банкны хувийн хэрэгт хадгална.

4.9. Банк нь гадаад улсад банкны нэгж байгуулах зөвшөөрлийг Монголбанкнаас олгосон тухай шийдвэрийг үндэслэн банкны нэгж байгуулах асуудлаар тухайн гадаад улсын төв банк буюу эрх бүхий байгууллагад хандана.

4.10. Тухайн улсын эрх бүхий байгууллагаас өөрийн нутаг дэвсгэр дээр Монгол Улсын банкны нэгж байгуулах зөвшөөрлийг олгосон шийдвэр, Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг тус тус үндэслэн Хяналт шалгалтын газар банкны гэрчилгээний хавсралтад тэмдэглэгээг хийж баталгаажуулна.

4.11. Хэрэв тухайн улсын эрх бүхий байгууллагаас дээрх зөвшөөрлийг олгохоос татгалзсан бол шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногийн дотор холбогдох албан бичгийг Хяналт шалгалтын газарт ирүүлнэ. Дээрхи баримт бичгийг үндэслэн Монголбанкнаас олгосон зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцох тухай шийдвэрийг Монголбанкны Ерөнхийлөгч гаргана.

Тав. Хяналт, хариуцлага

5.1. Банкны нэгжийн үйл ажиллагаанд банкны Гүйцэтгэх захирал, Дотоод аудитын газар, банкны нэгж хариуцсан газар (алба, хэлтэс) хяналт тавьж ажиллана.

5.2. Банкны нэгжийн улирлын тайланг энэхүү журмын 3 дугаар хавсралтын дагуу гарган

Монголбанкинд дараа улирлын эхний сарын 5-ны өдрийн дотор ирүүлнэ.

5.3. Монголбанк нь шаардлагатай тохиолдолд банкинд хийгдэх газар дээрхи иж бүрэн болон хэсэгчилсэн шалгалтын явцад банкны нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийнэ.

5.4. Монголбанк нь банкны төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина.

5.5. Монголбанкны зөвшөөрөлгүйгээр банкны нэгж байгуулсан бол Банкны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1.1-д заасан арга хэмжээ авна.

5.6. Энэ журамд заасан үндэслэлээр банкны нэгжийн үйл ажиллагааны зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдон гарсан зардлыг Монголбанк хариуцахгүй.

5.7. Монголбанк энэ журмын биелэлтэд хяналт тавьж, Банкны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----oOo-----

ГАДААДЫН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР БАЙГУУЛАХАД ШААРДЛАГАТАЙ
БАРИМТ БИЧГИЙН БҮРДЛИЙГ ШАЛГАХ ХҮСНЭГТ

.....банкны төлөөлөгчийн газар байгуулах хүсэлт, баримт бичгийг хүлээж авсан огноо:
20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

- Хүснэгтийг хар өнгийн балаар зөвхөн гарцаар бөглөнө
- Тухайн баримт бичгийг ирүүлсэн бол ✓ тэмдгийг, дутуу буюу огт ирүүлээгүй бол - тэмдгийг дугуйлна

д/д	Баримт бичгийн нэр		
1.	Төлөөлөгчийн газар үүсгэн байгуулах зөвшөөрөл олгохыг хүссэн гадаадын банк, санхүүгийн байгууллагын хүсэлт	✓	-
2.	Гадаадын банк, санхүүгийн байгууллагын захирлуудын зөвлөл, эсхүл түүнтэй адилтгах эрх бүхий удирдлагаас Монгол Улсад төлөөлөгчийн газар байгуулахаар гаргасан шийдвэр	✓	-
3.	Гадаадын банкны тухайн улсын банк байгуулах зөвшөөрөл олгох болон хяналт шалгалтын эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн болохыг нотлох баримт, Монгол Улсын нутаг дэвсгэрт банкны төлөөлөгчийн газар байгуулахыг зөвшөөрсөн тухай албан ёсны шийдвэр	✓	-
4.	Төлөөлөгчийн газрын удирдлагыг томилсон тухай шийдвэр	✓	-
5.	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар баталгаажуулсан гадаадын банк, санхүүгийн байгууллагын сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан болон	✓	-
6.	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэглэл тогтоодог байгууллагаас тогтоосон зэрэглэл	✓	-
7.	Энэхүү журмын 2 дугаар хавсралтын дагуу Төлөөлөгчийн газрын гүйцэтгэх удирдлагын боловсон хүчний анкет	✓	-
8.	Төлөөлөгчийн газрын үл ажиллагаанд мөрдөх журам, заавар	✓	-
9.	Улсын тэмдэгтийн хураамжийг Монголбанкинд төлсөн баримт	✓	-
10.	Төлөөлөгчийн газрын дүрэм	✓	-
11.	Бусад шаардлагатай асуудал	✓	-

Баримт бичгийн бурдэл шаардлага хангасан бол:

..... банкнаас ирүүлсэн Төлөөлөгчийн газар байгуулах хүсэлт, холбогдох баримт бичгийн бүрдэл бүрэн гүйцэд тул 20. . . оны . . . дүгээр сарын . . . -ны өдөр хүлээж авсан болохыг банкинд Монголбанкны 20. . . оны . . . дүгээр сарын . . . -ны өдрийн тоот албан бичгээр мэдэгдэв.

Баримт бичгийн бүрдлийг шалгасан:

ХШГ-ын хянан шалгагч (.....)
гарын үсэг нэр

Хянасан:

ХШГ-ын ахлах хянан шалгагч. (.)

гарын үсэг нэр

ХШГ-ын хэлтсийн захирал (.....)

гарын үсэг нэр

ХШГ-ын захирал. (.)

гарын үсэг нэр

Танылсан:

Тэргүүн дэд Ерөнхийлөгч, (.)

гарын үсэг нэр

Баримт бичгийн бурдэл шаардлага хангаагүй бол:

..... банкнаас ирүүлсэн Төлөлөгчийн газар байгуулах хүсэлт, холбогдох баримт бичгийн бүрдэл бүрэн бус тул Монголбанкны 20 . .оны . . дүгээр сарын . . -ны өдрийн . . . тоот албан бичгээр мэдэгдэв.

Дутуу баримтын жагсаалт:

- 1)
 - 2)
 - 3)
 - 4)
 - 5)
 - 6)

Баримт бичгийн бүрдлийг шалгасан:

ХШГ-ын хянан шалгагч (.....)
гарын үсэг нэр

Хянасан:

ХШГ-ын ахлах хянан шалгагч	(.)
гарын үсэг	нэр
ХШГ-ын хэлтсийн захирал	(.)
гарын үсэг	нэр
ХШГ-ын захирал.	(.)
гарын үсэг	нэр

Танылцсан:

Тэргүүн дэд Ерөнхийлөгч (.)
гарын үсэг нэр

“Банкны нэгжийн журам”-ын 2 дугаар хавсралт



Маягтыг хар өнгийн
балаар гаргацтай
зөвхөн гараар бичнэ.

.....БАНКНЫ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ТОДОРХОЙЛОЛТ

Регистрийн дугаар:

Иргэний үнэмлэхийн дугаар:

--	--	--	--	--	--	--	--

(иргэний үнэмлэхний нотариатаар гэрчилсэн хуулбарыг хавсаргана

1.ХУВЬ ХҮНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

- 1.1. Эцэг (эх)-ийн нэр Нэр
 - 1.2. Хүйс
 - 1.3. Төрсөн он сар өдөр
 - 1.4. Төрсөн газар
 - 1.5. Үндэс угсаа.....
 - 1.6. Хувь хүнтэй холбоотой доор дурьдсан мэдээлэлийг холбогдох байгууллагаас

3yraг
4 x 6

- 1.6.1. Зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өртэй эсэх,
 - 1.6.2. Гааль, татварын байгууллагад өртэй эсэх,
 - 1.6.3. Эдийн засгийн болон аж ахуйн гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан эсэх.

- #### 1.7. Гэр булийн байдал (Зөвхөн ам бүлд байгаа хумуусийг бичнэ)

Таны юу болох	Гэр бүлийн гишүүдийн эцэг /эх/-ийн нь болон өөрийн нь нэр	Төрсөн он	Төрсөн газар	Одоо эрхэлж буй ажил

2. БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

<i>Боловсрол</i>	<i>Хаана (улс болон хотын нэр) эзэмшил</i>	<i>Сургуулийн нэр</i>	<i>Эзэмшил боловсрол/хамгаалсан цол</i>	<i>Эзэмшил мэргэжил</i>
Дунд				
Дээд				

Гадаад хэлний мэдлэг: Англи □, Орос □, Герман □, Франц □, Хятад □, Солонгос □, Бусад □.
Мэргэшийн бэлтгэлийн талаар: (Ажил, мэргэжил, бусад чиглэлээр нарийн дадлагажсиж, мэргэшсэн байдлыг бичнэ)

Сургалтанд хамрагдсан улсын болон байгууллагын нэр	Хэзээ	Ямар чиглэлээр	Суралцсан хугацаа

3.ТУРШЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Ажилласан байгууллага, албан тушаалын нэр	Ажилд орсон	Ажлаас гарсан	Ажлаас гарсан шалтгаан

4.БУСАД МЭДЭЭЛЭЛ

4.1.Гэрийн хаяг: _____

4.2.Гар утасны дугаар: _____ Ажлын газрын утасны дугаар: _____

4.3.Цахим хаяг: _____

Тодорхойлолтыг үнэн зөв бичсэн:(.....)
гарын

үсэг

“Банкны нэгжийн журам”-ын 3 дугаар хавсралт



БАНКНЫ НЭГЖИЙН ӨӨРЧЛӨЛТ, ХӨДӨЛГӨӨНИЙ ТАЙЛАН

201...оны....дугаар сарын....өдөр

д/д	Салбарын тоо			Тооцооны төв			Тооцооны касс			Банкны нэгжийн тоо /эмнөх улирал/	Банкны нэгжийн тоо /тайлант улирал/	ӨӨРЧЛӨЛТ						
												Шинээр салбар нээсэн			Байршил өөрчлөгдсөн			Бусад
	УБ хот	Орон нутаг	Гадаад улс	УБ хот	Орон нутаг	Гадаад улс	УБ хот	Орон нутаг	Гадаад улс	а) банкны шийдвэр огноо	б) тоо	в) байгуулсан огноо	а) банкны шийдвэр огноо	б) тоо	в) өөрчилсөн огноо			
1																		
2																		
3																		
Нийт																		

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:

/нэр/

Салбар нэгжийн Удирдлагын газрын захирал:

/нэр/

Салбар нэгжийн Удирдлагын газрын ажилтан:

/нэр/